



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/369

Номгон

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит  
сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, 29.1.6-ын “ж”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.10, 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 67 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 154 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/342, А/365 дугаар захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 47 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль 2021 оны 6 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулахтай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн өдөр тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, сонгуулийн хороо, эмнэлгийн байгууллагуудын үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг түр зогсоож, иргэд олон нийтийг сонгууль өгөх нөхцөл боломжоор хангаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт,

2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгуулиас бусад олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулахыг түр хориглож, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зам тээврийн хөдөлгөөнд нэмэлт зохицуулалт хийж, иргэдийг харьяа нутаг дэвсгэрт очиж хуулиар хүлээсэн эрхийг эдлүүлэх нөхцөлөөр хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т,

3. Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис уусмал, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн бэлэн байдлыг хангах, сонгуулийн санал авах байруудад хяналтын байцаагч нарыг ажиллуулж, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтийг хангуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-т,

621010933


2.

4. Тусгаарлах эмнэлэг, сорьц, шинжилгээний хөдөлгөөнт лабораторийг бэлтгэж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т,

5. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх, хүч хэрэгслийн тооцоог тодотгож, үүсч болзошгүй эрсдэлээс иргэд, олон нийтийг хамгаалах, иргэдийг гамшиг осол, халдварт өвчний мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб (Онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Э.Батбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэ захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН